

Living the Lotus

Buddhism in Everyday Life

New Year's Issue

2022

2022 оны айлдвар

Өөдрөг тэмүүлэлтэй амьдарцгаая

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



“Дэлхий нийтээрээ энх тайван болоогүй цагт хувь хүний аз жаргалын талаар ярих боломжгүй”

Та бүхэнд шинэ оны мэнд хүргэе.

Уржнан жилээс авахуулаад корона вирусын аюул, хор уршиг бидний амьдралд ихээхэн нөлөө үзүүллээ. Япон дахь халдварын тоо сүүлийн үед эрс буурсан боловч дахин халдвар ихсэж байгаа улс ч байна. Тиймээс анхаарал сэрэмжээ сулруулалгүй халдвар хамгааллын дэглэмээ үргэлжлүүлэн сахицгаая.

Гишүүд маань бусдын төлөө гэсэн сэтгэлийн үүднээс нийгэмлэг хаалттай байсан ч гэсэн гишүүд рүүгээ утсаар ярьж, захиа бичиж, зурвас илгээн сургаалаа дамжуулсаар байгааг хараад та бүхнээр үнэхээр их бахархаж байна.

Би корона вирусыг хүний хамгийн чухал нандин зүйл юу болохыг олж харах боломж гэж хүлээж авцгаая гэж хэлсэн.

Халдварын үед “тэр хүн сайн байгаа

болов уу?”, “амьдрал нь гайгүй байгаа?”, “хүүхдүүд нь сайн байдаг байгаа” гэх зэргээр бусдын төлөө санаа тавих сэтгэл нь хүний хувьд хамгийн чухал нандин чанар юм. Ийм чухал нандин чанараа өнгөлөн зүлгэхийн хажуугаар өдөр тутмын амьдралаа эргэцүүлэн бодоод үзэх юм бол хэрэгцээ шаардлагагүй зүйлүүд нилээдгүй байгааг анзаарах болов уу.

Би өнгөрсөн жилийн айлдвартаа “эргэцүүлэх” гэдэг ханз үсэг хасаж танах ба эргэн харах гэсэн хоёр утгыг агуулдаг гэж дурдсан. Энэ хоёр жилийн хугацаанд бид юуг танаж, юуг эргэн харвал зохилтой болох нь бүр ч тодорхой болж ирсэн болов уу гэж бодож байна.

Японд корона вирус намжлаа гэж бодоход өөр оронд үргэлжилсээр байвал аюулын харанга хэзээ ч дахин дэлдэж болзошгүй.

Ийм дэлхий нийгмийн нөхцөл байдлыг харах ахуйд яруу найрагч Миязава Кэнжигийн “Дэлхий нийтээрээ энх тайван болоогүй цагт хувь хүний аз жаргалын талаар ярих боломжгүй” гэдэг үг олон зүйлийг бодогдуулна. Буддизмын агуу энэрэн нигүүлсэхүйн тухай ухагдахууныг орчин үеийн хэллэгээр илэрхийлсэн гэгддэг энэ сургамжийг өөр хоорондоо дахин тунгаан бодож үзүүштэй юм.

Ингээд “2022 оны чиг шугам”-ыг би ийнхүү тодорхойллоо: “Энэ жил байгууллага 84 жилийн ойтойгоо золгож байгаа ба миний бие Үүсгэн байгуулагчаас ном өвлөн авч байгууллагын ерөнхийлөгчийн үүрэг хүлээнээс хойш 30 жил өнгөрчээ.

Энэ жил ч бас тусгаарлалтын дэглэм үргэлжлэх төлөвтэй байна. Нийгмийн энэ нөхцөл байдалтай уялдуулан бид сүсэг бишрэл бүхий амьдралаараа дамжуулан эхнэр нөхөр, ээж аав, эцэг эхийн хувиар ирээдүйг бүтээх хүүхэд залуусын хүмүүжил, төлөвшил, мөн өрх гэрээ товхинуулахад анхаарвал зохилтой. Цаашлаад улс орныхоо өв соёл, уламжлалыг залгамжлан, эв нэгдэл бүхий энх тайван улсыг бий болгохын төлөө бүтээлч санаачлагатай, идэвхи зүтгэлтэй байхыг уриалж байна.”

Би өнгөрсөн жил бидний үндсэн зорилт бол “Хүн бэлдэх” буюу хүний хөгжил гэж хэлсэн. Үүний төлөө эхнэр нөхөр (залуу гэр бүл), ээж аав (дунд насныхан), эцэг эх (ахмад насныхан) гээд бүх насныхан хичээж зүтгэх хэрэгтэй. Энэ бол манай байгууллага төдийгүй нийгэм, улс орны хувьд нэн чухал үйл юм.

Энэхүү үйл хэрэг гэр бүлийн хүмүүжлээс эхэлнэ. “Өрх гэрээ товхинуулах” буюу гэртээ үр хүүхдээ чанартай өсгөн хүмүүжүүлж, сахилга батыг зааж сургаж байж цэцэрлэг, сургуулийн боловсролын үр шим гардаг. Гэрийн хүмүүжил, нийтийн боловсрол хоёр нэгдэж байж “хүн бэлдэх” үйл хэрэг жинхэнэ утгаараа цогц болдог.

Өрх гэрээ товхинуулахын тулд “Бурхан тахилаа дээдэлж амьдрах” мөн “Гэрийн гурван дадал” буюу өглөөний мэндчилгээ хийх, хүн дуудахад хариутай байх, тайлсан гутлаа зэрэгцүүлж тавих гурвыг дадал болгох чухал. Тус нийгэмлэгийн гишүүний хувьд энэ бол нэн тэргүүнд хэрэгжүүлбэл зохих үйл болно.

Энх тайван улс орныг бүтээн байгуулахын төлөө хүн бүр чин хүсэл эрмэлзлэлтэй, бүтээлч санаачлагатай байх

Хүүхэд залуусыг өгсөн хүмүүжүүлэх дээр нэмээд “2022 оны чиг шугам”-д “Улс оныхоо өв соёл, уламжлалыг залгамжлан эв нэгдэл бүхий энх тайван улсыг бүтээн байгуулахын төлөө зүтгэх” гэсэн нэг өгүүлбэр нэмсэн.

Эрт дээр үед Япон улсын нэрийг “Ямато” гэдэг байсан ба “агуу эв нэгдэл, энх тайван” гэсэн утгатай. Энэ бол Япон улсын эртнээс баримталж ирсэн үзэл санаа юм.

Хунтайж Шоотокү (593-622) өөрийн санаачилсан “17 зүйлт үндсэн хууль”-ынхаа хамгийн эхэнд “Улс орны үнэ цэн бол эв нэгдэл юм” хэмээсэн байдаг. Энэ үзэл санаа тухайн үеийн Япон улсын үндэс суурь байсан ба одоо ч Япон үндэстний оюун санаанд гүн гүнзгий шингэсэн хэвээр байдаг.

Түүнчлэн Япон улсын өв соёл, түүхэн уламжлал хаант засаглалтай салшгүй холбоотой гэж үздэг.

Японы хааны гэр бүлийнхэнд эртнээс ургийн овог гэж байгаагүй. Энэ нь ард иргэдтэйгээ нэгэн бүхэл гэсэн санааг илэрхийлдэг. Японд улс гүрэн бий болсноос хойш олон бэрхшээлийг даван туулж, Японы өвөрмөц онцлог бүхий соёл, ёс заншлыг бүтээж, уламжилж ирсэн нь ямар ч цаг үед хаан нь улсынхаа багана болж, ард иргэд нь эвлэлдэн нэгдэж хамтдаа зүтгэж ирсний үр дүн юм.

Харин дэлхийн 2-р дайнаас хойш Япон улс эдийн засгийн ашиг хонжоо, үр өгөөжийн хойноос хөөцөлдөн, Японы түүх, соёл, үзэл санааг уландаа гишгэн мартсан гэж зэмлүүлж байгаа.

Өнөө үед дэлхийн улс орнууд өөрийн улсын эрх ашгийг нэгдүгээрт тавих үзэл хүчтэй болж. Тиймээс Япон улс дэлхийн нэгэн улс гүрний хувиар түүхэн уламжлалдаа шингэсэн “эв нэгдэл” хэмээх үзэл санааг бүрэн дүүрэн ашиглаж, олон үүрэг хариуцлага хүлээх хэрэгтэй хэмээн бодогдоно.

Үүний тулд бид эхлээд өөрийн улс орныг засан товхинуулах шаардлагатай. Улс орны бүтээн байгуулалтыг зөвхөн төр засгийнханд даатгаад орхих бус иргэн бүр холч ухаан, бүтээлч санаачлагатай, идэвх зүтгэлтэй байх хэрэгтэй.

“Сэтгэлээ боловсруулах” гэдэг нь
жинхэнэ өөрийгөө танин мэдэх явдал

Ерөнхий чиг шугамд дурдсанчлан өнгөрсөн жилийн 11-р сарын 15-нд Үүсгэн байгуулагчаас ном өвлөн авсны 30 жилийн ой тохиосон. Эргээд харахад 30 жил болчихсон гэж үү гэсэн сэтгэгдэл төрж байна.

Тэр мөчөөс өнөөг хүртэл би “Мөр зэрэгцэн хамтдаа урагш ахицгаая” хэмээн уриалсаар ирсэн.

Гишүүн бүр бүгд адилхан бурханлаг чанартай. Би ч бас нэгэн бодисадвагийн хувиар та бүхэнтэй хамтдаа бурханы зам мөрөөр алхах



болно гэсэн миний үзэл бодол энэ үгэнд шингэсэн. Ном өвлөн авсны дараах жил буюу 1992 онд “Садан төрлийн айлчлал” хэмээх үйл ажиллагааны хүрээнд би 130 салбар нийгэмлэгээр зочлон, сүсэгтэн олонтойгоо уулзаж танилцсан билээ.

Хүмүүс бид бие биенээ түшиж, өөр хоорондоо харилцан хамааралтайгаар амьдардаг. Бүр том зургаар харах юм бол хүн төдийгүй сансар огторгуйн хамаг амьтан бүхэн бидний садан төрөл гэж хэлж болно. Тэр дундаа хамгийн ойрын, сэтгэл санаагаа ойлголцдог садан төрөл бол сүсэг нэгт хамт олон юм. Тийм учраас би нийгэмлэгээр зочлох үйлийг “Садан төрлийн айлчлал” гэж нэрлэсэн учиртай.

Үүсгэн байгуулагч энэ нэршлийг сонсоод “Садан төрөл гэж сайхан үг байна шүү”, “Сүүлийн үед Ничикоогийн царай нь гэрэлтээд нийгэмлэг явдаг болж. Аль дээр л номоо өвлүүлэх байж” хэмээн ихэд баяртайгаар хошигнон ярьж байсан юм.

Гэвч 8 жилийн дараа буюу 1999 оны 10-р сарын 4-нд Үүсгэн байгуулагч 92 насандаа бурханы оронд заларсан билээ. Тэр хүртэл ямар нэгэн юм болвол Үүсгэн байгуулагч байгаа юм чинь санаа зоволтгүй гэж боддог байсан боловч түүний насан эцэслэсэн явдал биднийг өөрсдөө биеэ даах хэрэгтэй болсныг ухааруулсан.

Үүсгэн байгуулагч товчхондоо эцэг эхээ халамжлах, өвөг дээдэстэй буян хийх, бодисадвагийн үйлд шамдах гурвыг зааж сургаж ирсэн гэж би үргэлж хэлдэг.

Тэр дундаа бодисадвагийн үйл буюу өөрөөсөө бодь сэтгэлийг төрүүлэн бодисадвагийн зам мөрийг хэрэгжүүлэх нь бурханы сургаалын цөм болдог. Бүр ойлгомжтой хэлэх юм бол энэрэн нигүүлсэх сэтгэлээр аливаад хандах явдал болно. Үүсгэн байгуулагч үүнийг л хамгийн ихээр захихыг хүссэн болов уу.

Үүсгэн байгуулагчаас шууд сургаал сонссон гишүүд жил ирэх тусам цөөрсөөр байна. Тиймээс тэдгээр гишүүдээсээ Үүсгэн байгуулагчийн сургаалаар дамжуулж ойлгож ухаарсан зүйл, аз жаргалыг олсон туршлагаа олон хүмүүстэй хуваалцаарай хэмээн хүсэх байна.

Ном өвлөн авснаас хойш миний хамгийн ихээр дамжуулахыг хүссэн зүйл бол хүн бүр жинхэнэ өөрийгөө танин мэдээсэй гэсэн хүсэл байсан. Бусдыг шүүмжилж, нийгмийн алдаа оноог шүүх амархан. Гэвч хамгийн чухал зүйл бол өөртөө дүгнэлт хийж өөрийгөө олох явдал билээ. Тэгвэл өөрийгөө танин мэдэхийн тулд яах хэрэгтэй вэ? Үүний тулд “сэтгэлээ боловсруулах” чухал гэсэн утгаар би байгууллагын 60 жилийн ойгоор “Сэтгэлээ боловсруулцгаая” гэсэн уриа дэвшүүлж, өнөөг хүртэл энэ зорилгын төлөө та бүхэнтэй хамтдаа алхсаар ирсэн.

Хүн хязгаарлагдмал өчүүхэн жижиг өөрийгөө “би” хэмээн бодсоноор өөрийгөө голж эсвэл онгиороо сагсуу зан гаргадаг. Гэвч энэ нь “жинхэнэ би” мөн болов уу?

Шагжамүни будда бидэнтэй адилхан хүн байсан ба зовж шаналж, бэрхшээлийг даван туулснаар ертөнцийн хуулийг гэгээрсэн. Тэгэхээр адилхан хүмүүс бидэнд угтаа жинхэнэ үнэний хуулыг гэгээрэх, асуудлыг өөрийн ухаанаар шийдэх чадвар байх учиртай.

Ийм жинхэнэ өөрийгөө танин мэдэх юм бол амьдралын олон саад бэрхшээлийг даван туулж чадна. Улмаар гэгээлэг эрч хүчтэй амьдрал өмнө тань нээгдэнэ.

Тэгэхээр “Сэтгэлээ боловсруулах” гэдэг нь эцсийн эцэст өөрийгөө танин мэдэх явдал юм. Яг одоо энэ дэлхийд амьдарч буй би бол Шагжамүни буддатай адилхан зүрх сэтгэлтэй, өөрийн амьдрал, дэлхий нийгмийн асуудлыг шийдвэрлэх чадвартай, ийм үүрэг хариуцлага хүлээсэн хүн хэмээн өөрийнхөө мөн чанарыг танин мэдэх нэн чухал.

Ном өвлөн авснаас хойших 30 жилийн хугацаанд үүнийг ухаарч, өөдрөг эрч хүчтэй амьдралыг туулж буй сүсэгтэн олны тоо яах аргагүй өссөн. Гэхдээ жинхэнэ өөрийгөө танин мэдээгүй байгаа хүн ч олон байна.

Тиймээс гишүүд маань цаашид ч гэсэн сургаал дамжуулах, гишүүн элсүүлэх үйлсэд шамдаж, бурханы сургаалын жинхэнэ үзэл санааг ухааран өөрийн болгоосой хэмээн чин сэтгэлээсээ хүсэж байна.

Энэ жил ч бас корона цар тахал үргэлжлэн хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байж магадгүй. Гэсэн хэдий ч “Энэ газар бол зам мөрийн газар” буюу яг одоо байгаа газар маань сургаал хэрэгжүүлэх газар гэсэн ухамсраар зам мөрд үргэлжлүүлэн шамдацгаая. Түүнчлэн нийгмийн хамгийн жижиг нэгж болох өрх гэрээ товхинуулж, ирээдүйг бүтээх залуу үеийнхэнтэй хамтдаа өсөж хөгжиж, өөдөө тэмүүлцгээе хэмээн уриалж байна.

